



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2016 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 4/30

Улаанбаатар хот

Дагалдах мөнгөн шагнал олгох тухай

Монгол улсын Засгийн газрын 2012 оны "Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай" 142 дугаар тогтоол, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын 2014 оны "Шагналын журам, тэмдгийн загвар батлах тухай" 49, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын "Шагнах тухай" А/62 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын "Шагнах тухай" А/62 дугаар тоот тушаалаар Засгийн газрын шагнал "Мэдээлэл, харилцаа холбооны тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын "Жуух бичиг"-ээр шагнагдсан албан хаагчдад олгох дагалдах мөнгөн шагналыг хавсралтаар баталсугай.

2. Дагалдах мөнгөн шагналд шаардагдах 160.000₮ (нэг зуун жаран мянга) -ийг холбогдох зардлын зүйл ангиас тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Б.Очир) -д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, аж ахуйн албаны дарга (Л.Оюунчимэг)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Ч.БАТ-ЭРДЭНЭ

420342